

10.0 (24)

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

**ГЕОЛОГИЙН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

2020 оны 09 дугаар
сарын 24 ны өдөр

Дугаар УАА-2020/32А

Улаанбаатар хот

ЗОРИЛГО:

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд Тавантолгойн ордын ашигт малтмалын нөөц тогтоолт, нөөцийн хөдөлгөөн, хайгуулын ажлын үр дүнд шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

1. ҮНДЭСЛЭЛ:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 4/233 дугаар албан бичиг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд гүйцэтгэлийн аудитыг хийнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно” гэж заасны дагуу уул уурхайн геологи, гидрогеологийн инженер мэргэжлээр мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийг аудитад татан оролцуулах шаардлагатай байна.

2. ЗОРИЛТ:

Шинжээч нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн талбайд 2018-2019 онуудад хийгдсэн ордын болон үйлдвэрлэлийн геологи хайгуулын ажлын үр дүн, нөөц тогтоолт, дагалдах ашигт малтмалын нөөц тогтоолт, нөөцийн шилжилт хөдөлгөөнийг ЭБМЗ-ийн хуралдааны тэмдэглэл, дүгнэлт, уулын ажлын төлөвлөгөө тайлан, ТЭЗҮ, хайгуулын ажлын тайлан мэдээ, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээ, зураглал, бусад холбогдох баримт материалд тулгуурлан тулган баталгаажуулалт хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна.

3. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖИЛБАРУУД:

Шинжээч нь ажлын даалгаварт туссан зорилтын хүрээнд дараах ажилбаруудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 онд уулын ажлын өрнөлт, олборлолт явуулсан талбайгаас олборлосон нүүрс, хөрсний хэмжээг тооцох, өөрийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөөц тогтоолт, түүний шилжилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийх;

3.2. Хайгуулын болон нарийвчилсан хайгуулын үед дагалдах ашигт малтмалын нөөцийн судалгаа хийгдсэн эсэхэд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах;

3.3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн ордын нөөц, баялгийг нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэхэд хэрэглэгдэх усны нөөцийн хайгуул, судалгааг оновчтой хийсэн эсэхэд дүгнэлт гаргаж, зөвлөгөө өгөх;

3.4. Үндэсний аудитын газрын аудитын багаас тодруулах асуудлын хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

4. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Шинжээч нь Монгол Улсын Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг бүрэн хамруулж дүгнэлт гаргана.

5. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН:

Шинжээч нь ажлын даалгаварт тусгагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын зорилт үр нөлөөтэй байгаа эсэхийг хянан үзэж дүгнэлт гаргаж, үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

6. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын баг бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаварт тусгагдсан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан шинжээч нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Гүйцэтгэлийн аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Шинжээч нь аудитын талбарын үе шатнаас эхлэн тайлагналын үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

Эхлэх хугацаа: 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дуусах хугацаа: 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

8. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Шинжээчээр иргэн, баг болон хуулийн этгээд оролцож болно. Шинжээч нь дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай байна. Үүнд:

- Уул уурхайн геологич мэргэжилтэй магистр буюу түүнээс дээш салбарын зөвлөх инженер болон мэргэшсэн зэрэгтэй;
- Уул уурхайн салбарт 10 буюу түүнээс дээш жил инженерээр ажилласан туршлагатай;
- Уул уурхайн нүүрсний чиглэлийн инженерээр ажиллаж байсан бол давуу тал болно;

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

9. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

Хянасан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНГЭРЭЛ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЕНЕЖЕР



Н.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.САРУУЛ

АХЛАХ АУДИТОР



Б.БАТДЭЛГЭР

Боловсруулсан:

АУДИТОР



Ц.ЦОЛМОН